



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/579

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3, 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV хуралдааны XIV/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Орхон сумын цэвэр усны даралтад цамхаг барих 2 дугаар шатны ажлыг 200,000,000 (хоёр зуун сая) төгрөгөөр “Сайхан хульж” ХХК-тай гэрээ шууд байгуулах эрхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гэрээнд заагдсан ажлыг зураг төсвийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг “Сайхан хульж” ХХК (Д.Төмөрбаатар)-д үүрэг болгосугай.

3.Цэвэр усны даралтад цамхаг барих 2 дугаар шатны ажлын гүйцэтгэлд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж хүлээн авахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4.Дээрх ажлын санхүүжилтийг аймгийн байгаль хамгаалах сангийн батлагдсан төсөл арга хэмжээнээс гэрээнд заасан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг сангийн нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010621

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын
07-ны өдрийн А/579 дугаар захирамжийн хавсралт



№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	3,201,939	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн албаны зардал	3,201,939	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал	1,600,969	Ү.Бямбасүрэн
4	Нормчлолын сан	288,174	Ү.Бямбасүрэн
5	Инженер хайгуул, зураг төслийн ажлын зардал	-	Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоногт гэрээний үнийн 0.05 хувь, нийт алданги гэрээний үнийн 10 хувь байна	Д.Батцогт
7	Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь	Д.Батцогт
8	Ажил гүйцэтгэх хугацаа	60 хоног	Ү.Бямбасүрэн